



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны
Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2026-2029 оны Стратеги төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Б.Дашпүрэв)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Өнөрнасан)-т даалгасугай.

САЙД



Г.ДАМДИННЯМ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
2026 оны 01 дүгээр сарын 05 -ны өдрийн
А... дүгээр тушаалын хавсралт



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

(2026-2029 ОН)

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ ХЭЛЛЭГ	3
1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	4-5
2.1. Аж үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	6-7
2.2. Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	7-8
2.3. Уул уурхайн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	9-10
2.4. Газрын тосны салбарын бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	10-11
2.5. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	12-13
2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	14-15
3. АЛСЫН ХАРАА	16
4. ЭРХЭМ ЗОРИЛГО	16
5. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	16
5.1. Аж үйлдвэрийн салбар	16
5.2. Уул уурхайн салбар	19
5.3. Геологийн салбар	20
5.4. Цөмийн энергийн салбар	23
5.5. Газрын тосны салбар	24
5.6. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль, эрх зүйн орчин	26-27
5.7. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчин	27-29
5.8. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүний нөөц	29-31
6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	31
7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ	32
8. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ	
(2026-2029 ОН)	33

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
СЯ	Сангийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ЦЭКАА	Цөмийн энергийн комиссын Ажлын алба
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ШУА	Шинжлэх ухааны академи
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
МУИС	Монгол Улсын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн сургууль
ГУУС	Геологи, уул уурхайн сургууль
ХШУС	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
МТС	Мэдээлэл технологийн сургууль
ГХ	Геологийн хүрээлэн
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ПХ	Палеонтологийн хүрээлэн
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
АЕГ	Архивын ерөнхий газар
ҮДТ	Үндэсний дата төв
МГТБҮ	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ТББ	Төрийн бус байгууллага
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
ҮЧҮ	Үндсэн чиг үүрэг
ДЧҮ	Дэд чиг үүрэг

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасан.

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг үндэслэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/74 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А122 дугаар тушаалаар “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024-2028 оны Стратеги төлөвлөгөө”-г батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” 07 дугаар тогтоол батлагдаж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дээр дурдсан журмын 1.4-т “байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээ, бодлогын баримт бичигт орсон өөрчлөлт, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан стратеги төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно” гэж заасны дагуу Стратеги төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулав.

2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн (аж үйлдвэр, геологи, цөмийн энерги, уул уурхай, газрын тос) асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

Яамны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулиуд:	<ol style="list-style-type: none">1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;2. Агаарын бохирдлын тухай хууль;3. Ашигт малтмалын тухай хууль;4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;5. Гаалийн тариф, гаалийн татварын тухай6. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль;7. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;8. Газрын тосны тухай хууль;9. Газрын төлбөрийн тухай;10. Газрын тухай хууль;11. Газрын хэвлийн тухай хууль;12. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль;13. Захиргааны ерөнхий хууль;14. Зөвшөөрлийн тухай хууль;15. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;16. Зөрчлийн тухай хууль;
---	---

	<p>17. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай;</p> <p>18. Кибер аюулгүй байдлын тухай хууль;</p> <p>19. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;</p> <p>20. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;</p> <p>21. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого;</p> <p>22. Монгол Улсын Үндсэн хууль;</p> <p>23. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;</p> <p>24. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;</p> <p>25. Технологи дамжуулах тухай хууль;</p> <p>26. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай</p> <p>27. Төрийн албаны тухай хууль;</p> <p>28. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль</p> <p>29. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай;</p> <p>30. Төрийн хяналт шалгалтын тухай хууль;</p> <p>31. Төсвийн тухай хууль;</p> <p>32. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль;</p> <p>33. Тэмдэгтийн хураамжийн тухай хууль;</p> <p>34. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль;</p> <p>35. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль;</p> <p>36. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл;</p> <p>37. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль;</p> <p>38. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль;</p> <p>39. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;</p> <p>40. Үндэсний баялгийн сангийн тухай хууль;</p> <p>41. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль;</p> <p>42. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль;</p> <p>43. Хөдөлмөрийн тухай хууль;</p> <p>44. Гамшгаас хамгаалах тухай хууль;</p> <p>45. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;</p> <p>46. Хөрөнгө оруулалтын тухай хууль;</p> <p>47. Хууль тогтоомжийн тухай хууль;</p> <p>48. Цөмийн энергийн тухай хууль;</p> <p>49. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль;</p>
--	--

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны бүтцийн нэгжүүдийн ерөнхий, үндсэн болон дэд чиг үүргүүдийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

2.1 Аж үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг: Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого төлөвлөлт, хөгжлийн стратеги, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.			
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид	
Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого, стратегийг бодлогын үр нөлөө, уялдаа, хувилбарыг нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн тодорхойлж эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрдэс түүхий эдийг боловсруулах, металлургийн, химийн, металл хийцийн болон машин үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлдвэрлэл, технологийн паркийг бүсчилсэн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгох, шаардлагатай статистик мэдээ, мэдээлэл бэлтгэх, салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, судалгааг хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх, хөтөлбөр, төсөлд үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	ДЧҮ-1: Аж үйлдвэрийн салбарын стратегийн зорилтыг тодорхойлж, салбарын бодлогыг бусад салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд зорилго, зорилттой уялдуулж, урт, дунд, богино хугацаанд төлөвлөх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг болон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах;	Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд.	
	ДЧҮ-2: Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн бодлогтой уялдуулан хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоог дэмжих, паркийн хөгжлийн төлөвлөлтийг дэд бүтцийн хамтаар боловсруулах, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлагнах;	ДЧҮ-3: Аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах, хүнд үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх хувилбар боловсруулах, статистик мэдээ, мэдээлэл, судалгааны нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, олон нийтийг нээлттэй ил тод мэдээллээр хангах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоог дэмжих;	Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-4: Аж үйлдвэрийн салбарт шинжлэх ухааны ололт амжилтад суурилсан дэвшилтэт, тэргүүний техник, технологи, инновацыг нэвтрүүлэх, ногоон хөгжлийн төслүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, техник, технологийн түвшнийг үнэлэх, мэргэжил арга зүйгээр хангах;		Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон ТББ, аж ахуйн нэгжүүд.

	ДЧУ-5: Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшсэн мэргэжилтнийг бэлтгэх чиглэлээр холбогдох сургалтын болон төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан, хөтөлбөр боловсруулж хамтран ажиллах;	Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд.
	ДЧУ-6: Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбоотой дүрэм, журам, стандарт, норм нормативыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах;	Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд.
	ДЧУ-7: Аж үйлдвэрийн салбарт болон салбар хоорондын уялдааг хангах хэм хэмжээний акт, дүрэм, норм, техникийн шаардлага, стандарт, итгэмжлэл, нийцлийн холбогдолтой бичиг баримтуудыг боловсруулах, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд.

2.2 Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын хэрэгжилтийг хангах, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Геологи, эрдэс баялгийн салбарын бодлого, хууль тогтоомж, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, олон нийтэд таниулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон шийдвэр гаргахад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.	ДЧУ-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, ЭЗХЯ, ГХЯ, ЦЭК, ҮГА, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд
	ДЧУ-2: Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого, эрдэс баялгийн бодлогын санал, зөвлөмж боловсруулах, геологи, эрдэс баялгийн салбарын бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах, статистик, тоон мэдээллийг бүрдүүлэх, түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулах;	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, ЭЗХЯ, ГХЯ, ЦЭК, ҮГА, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд

	<p>ДЧҮ-3: Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг тогтоох, геологийн сэдэвчилсэн судалгаа, зураглал, эрэл, үнэлгээний ажлыг төлөвлөх, шаардагдах төсвийн саналыг боловсруулах болон цаашид баримтлах бодлого, чиглэл, хэтийн төлөвийг тодорхойлох чиглэлээр бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;</p>	<p>СЯ, ЭЗХЯ, ҮГА, АМГТГ, ГХ, ПХ, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд</p>
	<p>ДЧҮ-4: Улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, ашигт малтмалын хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, уул уурхайн тогтвортой хөгжлийг хангуулах чиглэлээр бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;</p>	<p>ҮГА, АМГТГ, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-5: Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, нийтэд ил тод, нээлттэй болгох чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;</p>	<p>ҮГА, АМГТГ, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-6: Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох, улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийж хэтийн төлөв тогтоогдсон газарт сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгах, тэдгээрийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх болон хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах чиглэлээр хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, зохицуулах;</p>	<p>ҮГА, АМГТГ, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-7: Цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлүүлэх, түүний хэрэгжилтийг хангах, зохицуулах;</p>	<p>ҮГА, АМГТГ, аж ахуйн нэгжүүд.</p>

2.3 Уул уурхайн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын хэрэгжилтийг хангах, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого, ашигт малтмалын ашиглалт, баяжуулалт, салбарын техник, технологийн бодлого, аюулгүй ажиллагаа, дэд бүтцийн төлөвлөлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежмент, уул уурхайн бүтээгдэхүүний худалдаа, экспортын бодлого, хууль тогтоомж, урт, дунд хугацааны стратеги боловсруулах, бодлогын удирдамжаар хангах	ДЧҮ-1: Уул уурхай, цөмийн энергийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;	ЗГХЭГ, ХЗДХЯ, БОУАӨЯ, ЦЭК, ҮГА, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-2: Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, салбар дундын уялдааг хангасан дэд бүтцийг байгуулах, хэрэгжүүлэх;	ЗГХЭГ, БОУАӨЯ, МУУҮА, Шинжлэх ухааны болон олон улсын байгууллагууд.
	ДЧҮ-3: Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үйл ажиллагаанд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, эдийн засгийн эргэлтэд оруулах болон салбарт тэргүүний технологи, инновац нэвтрүүлэх, нутагшуулах, шинэчлэх чиглэлээр санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хэрэгжүүлэх;	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, ЭЗХЯ, ГХЯ, БОУАӨЯ, ЦЭК, ҮГА, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-4: Бичил уурхайн үйл ажиллагааны дүрэм, журмыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, холбогдох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;	МБУДХ, АМГТГ, нутгийн захиргааны байгууллагууд.
	ДЧҮ-5: Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах болон салбарт тэргүүний технологи, инновац нэвтрүүлэх, нутагшуулах, шинэчлэх чиглэлээр санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хэрэгжүүлэх.	ЗГХЭГ, БОУАӨЯ, МУУҮА, Шинжлэх ухааны болон олон улсын байгууллагууд.
ҮЧҮ-2: Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хөгжлийн бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хөгжүүлэх, нийтэд ил тод, нээлттэй үйлчлэх, үйл ажиллагааг	ДЧҮ-1: Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах;	ЗГХЭГ, МУУҮА
	ДЧҮ-2: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн	ЗГХЭГ, БОУАӨЯ, МУУҮА, Шинжлэх ухааны болон олон улсын байгууллагууд.

<p>зохицуулах, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрмийг батлуулах, салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой эрх зүйн актуудын хэрэгжилтийг зохицуулах, салбарт байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдлын стандартыг нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, ногоон эдийн засаг, хөгжлийн чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхай, уулын үйлдвэрийн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах.</p>	<p>сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах;</p>	
	<p>ДЧҮ-3: Ашигт малтмал ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах;</p>	<p>ЗГХЭГ, БОУАӨЯ, ЭХЯ, МУУҮА, Шинжлэх ухааны болон олон улсын байгууллагууд.</p>
	<p>ДЧҮ-4: Уул уурхайн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журмыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p>	<p>ГБХНХЯ, БОУАӨЯ, АМГТГ, салбарын холбоод.</p>
	<p>ДЧҮ-5: Уул уурхайн салбарын судалгаа, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх;</p>	<p>АМГТГ, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-6: Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хууль, тогтоомжид заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангах;</p>	<p>ЦЭК, ҮГА, АМГТГ, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-7: Шинээр нээгдэх уурхай, уулын баяжуулах үйлдвэрийн техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх;</p>	<p>БОУАӨЯ, ГБХНХЯ, АМГТГ, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-8: Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, импорт, тэсэлгээний ажлын техник, технологийн шинэчлэл, аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;</p>	<p>ЗХЖШтаб, ТЕГ, ЦЕГ, ОБЕГ, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>

2.4 Газрын тосны салбарын бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

<p>Ерөнхий чиг үүрэг: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын хэрэгжилтийг хангах, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах</p>		
<p>Үндсэн чиг үүрэг</p>	<p>Дэд чиг үүрэг</p>	<p>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</p>

<p>Газрын тосны салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, ашиглалт, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, газрын тосны салбарын техник технологи, тоног төхөөрөмж, барилга байгууламж, хөдөлмөрийн аюулгүй байдлын норм, дүрэм боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, газрын тосны салбарын зах зээл, тооцоо судалгаа боловсруулах, бүтээгдэхүүний чанар, хяналтын тогтолцоог сайжруулах, бодлогын удирдамжаар хангах</p>	<p>ДЧҮ-1: Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний бодлого, төлөвлөлтийг зохицуулах, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, бусад холбогдох төрийн байгууллагууд, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагаатай холбогдсон бодлогыг зохицуулах, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-3: Газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаатай холбогдсон бодлогыг зохицуулах, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-4: Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барьж байгуулах чиглэлээр бодлого, төлөвлөлтийг зохицуулах, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-5: Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагаатай холбогдсон бодлогыг зохицуулах, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-6: Газрын тосны салбарын техник технологи, тоног төхөөрөмж, барилга байгууламж, хөдөлмөрийн аюулгүй байдлын норм, дүрэм боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, бусад холбогдох төрийн байгууллагууд, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧҮ-7: Газрын тосны салбарын зах зээл, тооцоо судалгаа боловсруулах, бүтээгдэхүүний чанар, хяналтын тогтолцоог сайжруулах, бодлогын удирдамжаар хангах;</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>

2.5 Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөв, санхүүгийн үр ашигтай байдалд хяналт тавих, хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах.			
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид	
ҮЧҮ-1: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны үйл ажиллагааны төлөвлөлт, түүнийг зохион байгуулах, Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежер, төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг чадварлаг албан хаагч бүхий мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг бүрдүүлэх, чадавхийг сайжруулах, тэдний ажлын үр дүн, мэргэжлийн түвшинд үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулах.	ДЧҮ-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах;	ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, ҮГА, ЦЭКАА, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.	
		ДЧҮ-2: Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;	ЗГХЭГ, ХНХЯ, БСШУЯ, АМГТГ, ҮГА, ТАЗ, АТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
		ДЧҮ-3: Цахим засаглалын багц хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллах;	ЦХИХХЯ, ХЗДХЯ, АМГТГ, ҮГА.
		ДЧҮ-4: Байгууллагын сүлжээ болон программ хангамж, техник хэрэгслийн ашиглалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	ЦХИХХЯ, ХЗДХЯ, АМГТГ, ҮГА
		ДЧҮ-5: Байгууллагын архив, албан хэрэг хөтөлөлтийг эрхлэн явуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах;	Төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэн, аж ахуйн нэгжүүд.
ҮЧҮ-2: Хууль тогтоомж, дүрэм журам, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, шаардлагатай тохиолдолд яамыг шүүх, арбитрад төлөөлөх, салбарын гадаад хамтын ажиллагааг	ДЧҮ-1: Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулах, өргөн барихад дэмжлэг үзүүлэх;	ҮАБЗ, ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, ҮГА, салбарын мэргэжлийн холбоод, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.	
	ДЧҮ-2: Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль, эрх зүйн орчны давхардал	ҮАБЗ, ЗГХЭГ, бүх яамдууд, АМГТГ, ҮГА, салбарын мэргэжлийн холбоод,	

хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх.	хийдлийг арилгах, хяналт тавих;	аймаг, нийслэлийн ЗДТГ аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
	ДЧҮ-3: Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн Сайд болон Төрийн нарийн бичгийн дарга, шаардлагатай тохиолдолд яамыг шүүх, арбитрт төлөөлөх, эрх ашгийг хамгаалах, эрх зүйн дэмжлэг үзүүлэх;	ЗГХЭГ, бүх яамд, бүх шатны шүүх, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
ҮЧҮ-3: Салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлэх.	ДЧҮ-4: Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын гэрээ, хэлэлцээрийн талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх.	ЗГХЭГ, ГХЯ, АМГТГ, ҮГА, Элчин сайдын яамд, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
	ДЧҮ-1: Сайдын багцын төсвийг үр ашигтайгаар төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, төрийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;	СЯ, ҮАГ, АМГТГ, ҮГА болон ЦЭКАА.
	ДЧҮ-2: Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын санхүүгийн тайланг салбарын сайдын нэгдсэн тайланд нэгтгэх;	ЗГХЭГ, СЯ, ҮАГ, АМГТГ, ҮГА, ЦЭКАА, төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагууд.
	ДЧҮ-3: Сайдын багцын хүрээнд хийгдэх төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах;	СЯ, ҮАГ, ТХААГ, АМГТГ, ҮГА болон ЦЭКАА.
	ДЧҮ-4: Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх;	ЗГХЭГ, СЯ, ҮАГ, АМГТГ болон ЦЭКАА, ОУ-ын байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид.
	ДЧҮ-5: Яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах.	СЯ, ҮАГ, яамны дотоод бүтцийн нэгжүүд.

2.6 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг: Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, хөгжлийн бодлогын баримт бичигт салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах, яам, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган тайлагнах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааны стратегийг боловсруулах, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, төсвийн санхүүжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах	ДЧҮ-1: Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, яам, агентлагийн үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах;	ЗГХЭГ, СЯ, АМГТГ, ҮГА, ЦЭКАА, аймаг, нийслэлийн ЗДТГ.
	ДЧҮ-2: Сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, төрийн өмчит хуулийн этгээд, байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах;	АМГТГ, ҮГА, ЦЭКАА.
	ДЧҮ-3: Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах;	ЗГХЭГ, СЯ, АМГТГ, ҮГА, ЦЭКАА.
	ДЧҮ-4: Иргэд, байгууллагын мэдээлэл, өргөдөл, гомдлын мөрөөр дотоодын хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт гаргах, шийдвэрлэх;	АМГТГ, ҮГА, ЦЭКАА.
ҮЧҮ-2: Аж үйлдвэр, геологи, уул уурхай, цөмийн энерги, газрын тосны салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, нэгдсэн удирдлагаар хангах, аж ахуйн нэгж байгууллагад төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалт хийх, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд учирч болзошгүй эрсдэлээс	ДЧҮ-1: Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах;	ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ.
	ДЧҮ-2: Цахим технологид тулгуурласан бүртгэл, мэдээллийн санг ашиглан тусгай зөвшөөрөл олгох;	ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, аймгийн ЗДТГ.

урьдчилан сэргийлэх, мэдээллийн сан үүсгэх, тайлагнах, үр дүнд дүн шинжилгээ хийх, ионжуулагч цацрагийн үүсгүүрийн холбогдох тусгай зөвшөөрөл олгох, үнэлгээ хийх, цахим технологид суурилсан цөмийн материалын болон цацрагийн үүсгүүрийн нэгдсэн бүртгэл хийх, техникийн магадлал, баталгаажуулалт хийх		
--	--	--

3. АЛСЫН ХАРАА

ЭРДЭС БАЯЛГААР НИЙГМИЙН ҮНЭТ ЗҮЙЛ БҮТЭЭНЭ.

4. ЭРХЭМ ЗОРИЛГО

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эрхэм зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрийн геологийн судалгааг дээшлүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгох замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.

5. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

5.1 Аж үйлдвэрийн салбар

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2025 оны 3 дугаар улирлын байдлаар оны үнээр 60.1 их наяд төгрөгт хүрээд байгаа бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 29.2 хувийг аж үйлдвэрийн салбар (уул уурхай, олборлолтын салбар 21.9 хувь, боловсруулах үйлдвэрлэл 5.2 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбар 2.2 хувийг) эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэл 10 хувиар буурсан, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл 10.9 хувиар, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбарын үйлдвэрлэл 30 орчим хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэл 70.4 хувийг, боловсруулах үйлдвэрлэл 22.7 хувийг, цахилгаан хий, уур, агааржуулалтын салбар 6.1 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 2025 оны 12 сарын байдлаар онд 59.5 их наяд төгрөгт хүрч, нийт борлуулалтын 77.3 хувь буюу 46 их наяд төгрөгийг уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар, 17.6 хувь буюу 10.4 их наяд төгрөгийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 4.6 хувь буюу 2.7 их наяд төгрөгийг цахилгаан, хий, уур агааржуулалтын салбар, 612.0 тэрбум төгрөг буюу 0.5 хувийг ус хангамжийн дэд салбар бүрдүүлсэн байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны мэдээллээр Орхон, Сэлэнгэ, Дархан-уул, Дорнод, Говьсүмбэр, Төв, Өмнөговь, Дорноговь, Улаанбаатар хотод 105 үйлдвэр, аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөлтэй хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төмөрлөг боловсруулах 75, машин, тоног төхөөрөмж эд анги үйлдвэрлэх 19, газрын тос, нүүрс боловсруулах чиглэлээр 7, үнэт металл, эрдэнийн чулуун үйлдвэрлэл чиглэлийн 4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 2025 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр 7,599 тн катодын зэс, 35.6 мян.тн металл бэлдэц, 33.5 мян.тн металл цувимал, 1 мянган тонн ган төмөр хийц, 125.6 тн цахилгааны утас тус тус үйлдвэрлэсэн байна.

2024 оны IV улирлын байдлаар эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарт 1,360 мянган хүн ажиллаж байгаагаас 106 мянга буюу 7.8 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 75.4 мянга буюу 5.54 хувь нь уул уурхай олборлолтын салбарт ажиллаж байна.

Түүхий эдийн экспорт давамгайлсан манай улсын хувьд аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж экспортын үндсэн түүхий эд болох нүүрс, газрын тос, зэс, төмрийн хүдрийн боловсруулалтын түвшнийг ахиулах замаар, дэвшилтэт техник, технологи, инновацад суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилт болон тавигдаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр “уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлэх, Монгол Улсын зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, дэд бүтцийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж хэрэгжүүлэх, Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны баяжмал боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулах, Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барих, Нүүрс-химийн технологийг эзэмших, хүний нөөцийг бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түлш, нийлэг материал, устөрөгч гарган авах” зэрэг зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын хөгжлийн үндсэн чиглэл” зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан аж үйлдвэрийн салбарын төслүүд болох Зэс боловсруулах цогцолборыг Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант суманд, Гангийн цогцолборыг Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор суманд, Нүүрс-хими, кокс химийн цогцолборыг Тавантолгой, Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний ордод түшиглэн Өмнөговь аймгийн Цогтцэций болон Нийслэлийн Багануур дүүрэгт, Хөтлийн шохойн чулууны ордод түшиглэн Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолборыг Сэлэнгэ аймгийн Орхон, Сайхан суманд, Бор-Өндөрийн хайлуур жоншны нөөцөд түшиглэн Жонш, цахиур боловсруулах цогцолборыг Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд төрийн өмчийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэлбэрээр, мөн хувийн өмчийн кокс-хими, нүүрс химийн цогцолборуудыг Дорноговь, Сүхбаатар аймагт үйлдвэрлэл технологийн паркийн хэлбэрээр байгуулж, орон нутгийн өмчит Налайх ҮТП, Багануур ҮТП, Багахангай ҮТП-ийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхээр төлөвлөж боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бодит өсөлтийг 2029 онд 5.9 хувьд хүргэхээр төлөвлөж байна.

Аж үйлдвэрийн салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Төр, засгийн зүгээс аж үйлдвэрийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх чиглэл баримталж буй хэдий ч эрх зүйн орчин тодорхойгүй, хүнд аж

үйлдвэр хөгжих угтвар нөхцөл бүрдээгүй, нөгөө талаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь томоохон дэд бүтцийн асуудлыг бие даан шийдвэрлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулах санхүүгийн нөөц боломж, туршлага дутмаг, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоо сул байна;

2. Уул уурхайн бүтээгдэхүүний брижийн тухай хууль 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс түүхий эд худалдан авч боловсруулах үйл ажиллагаа явуулж байсан үйлдвэрүүд түүхий эд худалдан авах боломжгүй болсноор үйл ажиллагаа нь бүрэн зогсонги байдалд орсон;

3. Аж үйлдвэрийн мега төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын зардал өндөр, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа урт тул тус салбарт хувийн хөрөнгө оруулалтыг татах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хамааруулах боломжийг бүрдүүлэх үүднээс төрөөс санхүүжүүлэх боломж байхгүй нь тодорхой боловч гадаадын хөрөнгө оруулагчдыг тухайн томоохон төслүүдэд хэрхэн татаж оролцуулах, олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг хөрөнгө оруулалтын аргаар хэрхэн явуулах нь эрх зүйн зохицуулалтгүй, эсхүл зохицуулалт нь холбогдох хууль, дүрэм, журмуудад харилцан уялдаагүй байгаагаас нэгдсэн оновчтой шийдэл гаргах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна;

4. Хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдвэрүүдийн хувьд ган туйван, арматур, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, цемент, машин үйлдвэрлэлийн болон металл хийцийн зарим үйлдвэрүүд бий болж, үйл ажиллагаа нь тогтвортой байгаа мэт боловч ихэнх үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа гол шалтгаан нь анхдагч болон хоёрдогч түүхий эдийн дутагдал бол үүнээс гадна сэлбэг, хэрэгсэл импортоос бүрэн хараат, мэргэжилтэй болон техникийн чадавх бүхий хүүний нөөц дутагдалтай, борлуулалтыг дэмжих механизм бүрдээгүй, тогтвортой санхүүжилтийн орчин, механизм төлөвшөөгүй учир эргэлтийн хөрөнгө дутагдалтай, шинэ техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх боломж хомс, эрчим хүч, дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ бүрэлдээгүйгээс дотоодын үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн ижил нэр, төрлийн импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байна;

5. Аж үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх зорилгоор 2015 онд баталсан “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хуулийг 2020 онд хүчингүй болсон, өнөөгийн дагаж мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хууль нь ашигт малтмалын хайгуул, олборлолт, баяжуулалт гэсэн үе шатны харилцааг зохицуулсан байдаг бол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль нь зөвхөн паркийн хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулж байгаагаас паркийн гадна үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа хуулийн зохицуулалтгүй орхигдоод байна. Хууль, эрх зүйн зохицуулалт бүрдээгүйгээс аж үйлдвэрийн суурь салбар болох хүнд үйлдвэрийн салбарыг дэмжин хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих нөхцөл боломж хязгаарлагдмал байна;

6. Инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх болон үйлдвэрлэл эрхлэгчдэд удирдлагын дадлага, ур чадвар эзэмшүүлэх тогтолцоог бий болгох, бэхжүүлэх замаар үйлдвэрлэл явуулахад

шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх асуудал тулгарч байна. Тухайлбал, Аж үйлдвэрийн чиглэлээр хэрэгжих томоохон төслүүд хэрэгжиж эхэлснээр 100 гаруй мэргэжлийн нийт 2,747 шууд ажлын байр нэмэгдэх ба үүний 35 хувь буюу 960 ажлын байранд тусгай дунд боловсролтой ажилтан шаардлагатай байгаа нь өнөөдрийн хөдөлмөрийн зах зээлд байхгүй зэрэг асуудлууд байна.

5.2 Уул уурхайн салбар

Уул уурхайн салбар нь 2025 оны гүйцэтгэлээр Дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, төсвийн орлогын 28 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 79 хувь, экспортын орлогын 93 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 74 хувийг тус тус бүрдүүлж байгаа нь энэ салбарын ач холбогдлыг тодорхойлно.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 27,013.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 384.5 (1.4%) сая ам.доллараар буурсан байна. Экспорт импортоос 4,389.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Нийт экспорт 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15,701.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 81.9 (0.5%) сая ам.доллараар буурсан байна. Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 14,677.1 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 111.9 (0.8%) сая ам.доллараар буурсан байна.

2025 онд 85.0 сая тн нүүрс, 2,010.0 мян.тн зэсийн баяжмал, 16.3 тн алт, 800.0 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал, 8,110.0 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 150.0 мян.тн цайрын баяжмал, 4,248.9 мян.бар газрын тосыг тус тус экспортлохоор төлөвлөсөн.

2025 оны урьдчилан гүйцэтгэлээр 90.0 (105.9%) сая тн нүүрс, 2,281.9 (113.5%) мян.тн зэсийн баяжмал, 8,799.8 (108.5%) мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 6.3 (96.1%) тн алт (Монголбанканд тушаасан), 3,523.0 (82.9%) мян.бар газрын тос, 149.2 (99.5%) мян.тн цайрын баяжмал, 1,818.1 (227.3%) мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг тус тус экспортолсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 32.6 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.2 (3.8%) их наяд төгрөгөөр өссөн байна. Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 9,269.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,114.2 (10.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 28.39 хувийг бүрдүүлж байна.

Эрдэс баялаг, цөмийн энергийн салбарын бодлого, үйл ажиллагааг зохицуулсан 50 орчим хууль өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа бол Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад эрх олгосон зохицуулалтын хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 65 акт батлагдаж, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.

Салбарын эрх зүйн зохицуулалт нь 1992 оны Үндсэн хуульд тулгуурлаж байгаа бөгөөд 1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай хууль болон Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтууд нь газрын хэвлийн баялгийн өмчлөл, ашиглалтын талаар баримтлах үндсэн зарчим болж байна.

Түүнчлэн УИХ-ын 2009 оны 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2019 оны 214 дүгээр

тогтоолоор “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байна.

Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн гаралтай түүхий эд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг УИХ-аар баталуулах ажил хийгдэж байна. Ингэснээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар харилцан ашигтай ажиллах, урт хугацааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж буй юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогод Аж үйлдвэрийн чиглэлээр эдийн засгийг эрчимжүүлэх 14 мега төсөл туссан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлснээр экспортын хэмжээ 2 дахин өсөж, нэг хүнд ноогдох ДНБ 10.600 ам.долларт хүрнэ хэмээн таамаглаж байна.

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн болон төгрөгийн ханшийн дарамтыг бууруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор “Алт-3” аяныг орон даяар зарлан хэрэгжүүлэх, үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Монгол, Францын хамтарсан ураны төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг судалж, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоол батлагдсан. Мөн Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Бадрах Энержи” ХХК-ийн Орд ашиглах шинэчилсэн гэрээний төслийг хэлэлцээд хууль тогтоомжийн дагуу гэрээнд гарын үсэг зурахыг Ашигт малтмал, газрын тосны газарт зөвшөөрсөний дагуу 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Орд ашиглах гэрээг шинэчлэн байгуулсан.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх насны 1,360.3 мянган хүн байгаагаас тус салбарт 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 75.4 мянган хүн ажиллаж байна.

Уул уурхайн салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Монгол Улсын хэмжээнд 21 аймгийн дийлэнх хэсэгт нь ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч салбарын яамны хувьд орон нутагт уул уурхайн асуудал хариуцсан биеэ даасан нэгж байдаггүйгээс салбарын бодлого, шийдвэр хэрэгжилтийн шатанд зөрчил, хийдэл үүсдэг;

2. Ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хувьд нэг зах зээлээс хэт хамааралтай, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин доогуур, эрх зүйн зохицуулалтгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд бий болсон, дэд бүтцийн хүрэлцээ муу байгаа нь салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна;

3. Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд хүргэж чадалгүй дамжуулан борлуулагч нарт худалдаалдаг, мөн түүнчлэн аж ахуйн нэгжүүд үнэ шилжилтийн аргыг ашиглаж байгаа зэрэг шалтгаанаар уул уурхайгаас хангалттай хэмжээнд ашиг хүртэж чадахгүй байгаа;

4. Томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай хэдий ч уул уурхайн томоохон төслүүдэд олгож буй санхүүгийн дэмжлэг болон зээлийн хүрэлцээ муу;

5. Иргэдийн зүгээс уул уурхайн салбарын талаарх ойлголт дутмаг, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын зүгээс салбарын эсрэг сөрөг сурталчилгаа явуулдаг, мөн түүнчлэн хууль бус ашигт малтмал олборлолт зэргээс үүдэн салбарын нэр хүнд муудаж байгаа зэрэг болно.

5.3 Геологийн салбар

Монгол Улсын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, үндэсний язгуур эрх ашгийг хангах, экологийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд геологийн зураглал, эрэл-үнэлгээ, агаар-сансрын тандан судалгаа, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн болон бусад региональ судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэснээр нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг танин мэдэж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах ач холбогдолтой. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил болон тодорхой талбайнуудад эрэл-үнэлгээний ажлыг гүйцэтгэснээр ашигт малтмалын хэтийн төлөв бүхий эрдсийн хуримтлалтай талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох, дунд хэмжээний ашигт малтмалын ордыг нээн улсын төсөвт орлого төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх, хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал, эрүүл мэнд, батлан хамгаалах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбарт ашиглагдах суурь мэдээллийн санг бүрдүүлэх юм.

Монгол Улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийн 46.9 хувь нь 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдсан бол агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлаар 70 хувь, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлаар 30 хувь, геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлаар 100 хувийг тус тус хамруулсан.

Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд 74 төрлийн ашигт малтмалын 3135 орд, 102 төрлийн 8892 илрэл тэмдэглэгдсэн. Үүнээс голлох 10 ашигт малтмалын нөөцийг задлан харуулбал: нүүрс 33.4 тэрбум.тн, төмрийн хүдэр 1.81 тэрбум.тн, зэс 59.6 сая.тн, цайр 1.1 сая.тн, гянтболд 415.2 мянган.тн, алт 418.5 тн, мөнгө 4259.1 тн, уран 192,2.3 мянган.тн, газрын ховор элемент 3099.2 мянган.тн тус тус бүртгэгдээд байна.

2024 оны 12 дугаар сарын 24-ний байдлаар нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 6.8 сая.га талбайд 2,733 тусгай зөвшөөрөл олгогдсон байгаа бөгөөд үүний 1.859 сая.га талбайд 1,751 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 5.005 сая.га талбайд 982 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Хайгуул тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 3.2 хувийг эзэлж байгаа бол ашиглалтын тусгай зөвшөөрөл 1.18 хувийг тус тус эзэлж байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн 31.9 хувийг алт, 17.9 хувийг нүүрс, 12.8 хувийг хайлуур жонш, 4.7 хувийг төмрийн хүдэр, үлдсэн хувийг барилгын материал, түгээмэл тархацтай ашигт малтмал болон бусад ашигт малтмал эзэлж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хөрөнгө оруулагч улсаар нь ангилж үзвэл 79.6 хувийг дотоодын хөрөнгө оруулагч, 15.8 хувийг гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, 4.6 хувийг хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд тус тус эзэлж байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтаар:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох хуучин журмын хүрээнд 2025 онд сонгон шалгаруулалтыг 834,722.79 га талбайд зарлаж, үүнээс 395,100.88 га талбайд 105 тусгай зөвшөөрлийг олгосон. Үүний үр дүнд улсын төсөвт 137.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.

Геологийн салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Уул уурхайн тогтвортой үйл ажиллагааг урт хугацаанд хангаж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн зорилготой геологийн суурь судалгааны ажлын төлөвлөгөөт онд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг УИХ-аас баталсан хэдий ч төсөв, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас сар бүрийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн хуваарийг хойшлуулах, хэд хэдэн сараар санхүүжилтийг хоцроох асуудал байнга гарч байна. Түүнээс гадна 2025 оны санхүүжилтийг 7 сараас хойш олголгүй оны эцэст 12 сард олгосон төдийгүй 4,9 тэрбум төгрөгийн ажлыг санхүүжүүлээгүй. Энэ нь 2026 оны төлөвлөлтийг дахин хийж, тухайн санхүүжилтийг шилжүүлэх шаардлагатай болгосон. Мөн санхүүжилтийг ажлын гэрээнд заасан нөхцлийн дагуу хугацаанд олгоогүйгээс судалгаа хийж буй гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн хүндрэл учруулж, судалгааны ажлын чанар, үр дүнд нөлөөлөхөд хүргэж байна.

2. Улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа болон байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зүгээс геологийн судалгааны ажлын хамрах хүрээ өргөн бөгөөд чиглэл нь олон төрөл байдаг онцлогийг харгалзан үзэлгүй түүний зөвхөн нэг чиглэл болох ашигт малтмал хайх ажилтай адилтган үзэж, дэмжлэг үзүүлэхгүй байна. Мөн Дархан цаазат газар нутагт геологийн судалгаа хийхийг хориглох тухай Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Энэ нь Монгол орны газрын хэвлийн судлах, түүнийг үнэлэх зорилгоор хийгдэж байгаа геологийн судалгааны ажилд шууд хориг болж байна.

3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын хүрээнд хээрийн судалгааг гүйцэтгэх үед ухамсар дорой орон нутгийн зарим иргэдийн шууд эсэргүүцэж, хууль бус шаардлага тавьж, саад тотгор учруулж байгаа байдал нийтлэг болж, геологийн судалгааны ач холбогдолыг орон нутаг дах төрийн захиргааны байгууллага, түүний удирдлагын зүгээс эсэргүүцэх чиг хандлага гарч байна.

Шийдвэрлэх арга зам:

- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын санхүүжилтийг сар бүр тогтвортой олгож, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндэс болсон газар нутаг, түүний хэвлийг судалдаг геологийн салбарт Улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;

- Үндэсний геологийн албыг бэхжүүлэх, чадавхижуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;

- Улсын тусгай хамгаалалттай газарт геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх хууль, эрх зүйн орчны бүрдүүлэх, төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх;

- Геологийн судалгааны ажил нь шинжлэх ухаан, үйлдвэрлэл хосолсон улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа захиалгат ажил гэдгийг орон нутгийн удирдлага, иргэдэд таниулан сурталчлах, судалгааны ажлыг аймаг, сумын Засаг даргын зүгээс зохион байгуулж, хамтран ажиллах, хууль зөрчиж буй этгээдэд хариуцлага тооцох;

- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх зарим геологийн судалгааны ажлуудыг хамрах хүрээ, үр дүн, нууцлал, мэдээллийн боловсруулалтын түвшин зэргээс хамааруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалтаар бус Үндэсний геологийн албаны шууд удирдлага дор төслийн баг бүрдүүлэн гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн хэрэгжүүлэх.

5.4. Цөмийн энергийн салбар

Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмалын 13 ордын хэмжээнд 192,241.02 мянган тонн геологийн нөөц бүртгэгдэж, үүнээс 11 ордын нөөцийг нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн бүртгэн авсан. Нийт нөөцийн 67 хувийг нь газар дор уусган олборлох аргаар ашиглахад тохиромжтой.

Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 4 аймгийн 9 сумын нутагт нийт 98.46 мянган гектар талбайд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 3, ашиглалтын 8 тусгай зөвшөөрөл байгаа боловч өнөөгийн байдлаар олборлолт, боловсруулалтын хэрэгжсэн төсөл байхгүй байна.

Монгол Улсын хэмжээнд цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологи ашиглах тусгай зөвшөөрөл бүхий нийт 669 аж ахуйн нэгж, байгууллагад 2327 цацрагийн үүсгүүр бүртгэлтэй байгаагаас 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад 1-5 дугаар ангиллын 400 гаруй цацраг идэвхт битүү үүсгүүрийг аж үйлдвэр, цооногийн өрөмдлөг, зэвсэгт хүчин, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн салбарт ашиглаж байна. Цацрагийн үүсгүүрийн хэрэглээ, нэр төрөл, тоо өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд 2021-2024 онд улсын хэлээр ойролцоогоор жилд 140-170 цацрагийн үүсгүүр импортлогдсон.

Улсын хэмжээнд цөмийн болон цацраг идэвхт, цацрагийн үүсгүүрийг төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах чиг үүрэг бүхий Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Изотоп контор нь ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалыг төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг явуулж байна.

Цөмийн энерги ашиглах салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих зохицуулалт байхгүй байна;

2. Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи ашиглах салбарын асуудалд цогцоор нь өөрчлөлт, шинэчлэлтийг оруулалгүй орхигдуулж байсан нь сургалт зохион байгуулах, хүний нөөцийг бэлтгэх, тогтвортой хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаа, цар хүрээ, түүний эрсдэлээс нь хамааран тохирсон шаардлага тавих, аюулгүйн үнэлгээ хийхэд олон улсын зэрэглэсэн хандлагыг хэрэглэх эрх зүйн орчин бүрдэхгүй байна;

5.5 Газрын тосны салбар

Газрын тосны салбарт Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, эдгээр хуулийн хүрээнд хүчин төгөлдөр мөрдөж буй дүрэм, журмууд үйлчилж байна.

Өнөөдрийн байдлаар манай улс шатахууны хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна. Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийг дагаад манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж ирсэн бөгөөд 2021 онд 1.8 сая тонн, 2022 онд 1.9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж байсан бол 2023 онд импортын хэмжээ 2.4 сая тонн, 2024 онд 2.8 сая тонн, 2025 онд 2.9 сая тонн болж өмнөх оноос даруй 3.6 хувиар өссөн бөгөөд цаашид тасралтгүй өсөн нэмэгдэх төлөвтэй байна.

Бүх төрлийн шатахууны импортын тусгай зөвшөөрөлтэй 170, бөөний худалдаа эрхлэх 180, жижиглэнгийн тусгай зөвшөөрөлтэй 180 ААН-үүд байна.

Газрын тосны эрэл, хайгуулын чиглэлээр:

Өнөөгийн байдлаар газрын тосны хайгуулын 30 талбай байгаагаас 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу хайгуулын 10 талбайд үйл ажиллагаа явуулж байна.

Уламжлалт бус газрын тос буюу нүүрсний давхаргын метан хийн хайгуулын хувьд өнөөгийн байдлаар үйлдвэрлэлийн ашигтай нөөц бүхий орд газар хараахан тогтоогдоогүй байгаа бөгөөд метан хийн хайгуулын Номгон IX, Богд IV, Онги V, Т1, Тавантолгой XXXIII, Гурвантэс XXXV, Төв XXXVI, Ачит XXXVII зэрэг нийт 8 талбайд 6 гэрээлэгч аж ахуйн нэгж БХГ-ний дагуу хайгуул, судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

Газрын тосны олборлолт, ашиглалтын чиглэлээр:

Монгол Улсын хэмжээнд газрын тосны БХГ-т 4 талбайд олборлолтын үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

1993 онд Тосон-Уул XIX, 1995 онд Тамсаг XXI талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг Петрочайна Дачин Тамсаг ХХК 2005 онд шилжүүлж авсан, 1997 оны БХГ-т талбайн гэрээний эрх үүргийг Доншен Газрын тос (Монгол) ХХК 2003 онд шилжүүлж авсан, 2010 онд Матад XX талбайд Петроматад ХХК гэрээ байгуулж хайгуулын ажлын үр дүнд газрын тосны нөөцийг тогтоож олборлолт, ашиглалтын үйл ажиллагааг явуулж байна.

Өнгөрсөн хугацаанд буюу 1993-2024 онд хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт 1,731 цооног өрөмдөж, 13.6 мянган тууш км хоёр хэмжээст, 5.4 мянган км² гурван хэмжээст чичирхийллийн судалгаа хийсэн. 1993-2024 онд Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ-97, Матад XX талбайд нийт 4.28 тэрбум ам.доллар (2019-2024 оны тоон мэдээ санхүүгийн шалгалтаар баталгаажуулахгүй дүн болно)-ын хөрөнгө оруулсан.

Газрын тосны нөөц: Газрын тосны хайгуулын ажлын үр дүнд Тосон-Уул (Тосон-Уул XIX талбай)-2011 он, Тамсагийн (Тамсаг XXI талбай)-2012 он, Зүүнбаян, Цагаан-Элс (БХГ-97 талбай)-2011 он, Цэн Тогоруу (Матад XX талбай)-2021 он, Өлгийн (Галба XI талбай)-2024 онд тус тус ордуудын нөөц тогтоогдож, ордуудын нөөцийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн.

Нийт баталгаат геологийн нөөц нь 335.6 сая тонн, үүнээс олборлох

боломжтой буюу ашиглалтын нөөц нь 43.59 сая тонн байна.

Монгол Улсын хэмжээнд 1998-2024 оны хооронд нийт 11.5 сая тонн газрын тос олборлож, 11.05 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолж, борлуулалтын орлогоос 2.73 их наяд төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн ба үлдэгдэл ашиглалтын нөөц 32.09 сая тонн байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна”, “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө” гэж, 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна” гэж, 2021 оны 106 тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогод “Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана” гэсэн зорилтууд тусгагдсан.

Эдгээр зорилтуудын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэр болон тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажил явагдаж байгаа ба 2028 оны эхний улиралд ашиглалтад орно. Газрын тос боловсруулах үйлдвэр жилд 1.5 сая тонн газрын тос хүлээн авч боловсруулах хүчин чадалтай.

Газрын тосны салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Тосон-Уул, Тамсагийн ордуудын “Ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г анх 2012 онд хүлээлгэн өгсөн ба сүүлийн 5 жилийн түүхий тосны зах зээлийн үнийн уналтаас хамааран тус төлөвлөгөөний дагуу ордыг эдийн засгийн үр ашигтай ашиглах боломжгүй болж байна. Тодруулбал, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2020 он гэхэд дээрх 2 ордоос олборлох тосны хэмжээ 1.5 сая.тн-д хүрэх ёстой хэдий ч бодит байдал дээр 1.0 сая.тн-д хүрэхгүй байна. Иймд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж цооногийн өрөмдлөг, шингэн хагалбар, цооногийг олборлолтын тоног төхөөрөмжөөр тоноглох, ус шахалтын хэмжээг нэмэгдүүлэх зэрэг нэмэлт ажлуудыг хийхгүй тохиолдолд дээрх 2 ордоос олборлох түүхий тосны хэмжээ нэмэгдэх боломжгүй болоод байна;

2. Газрын тосны олборлолтын үйл ажиллагаанд шаардлагатай цахилгаан эрчим хүчний дутагдлаас үүдэн “Тосон-Уул XIX” болон “Тамсаг XXI” талбайнууд дахь 100 гаруй цооногийн олборлолтыг зогсоож, хоногт 240 тн тос дутуу олборлож байгаа бөгөөд өвлийн улиралд 5-6 МВт-ын цахилгаан эрчим хүчний дутагдал үүсч, сар бүр 12,000 тн тос дутуу олборлохоор байгаа нь олборлолтын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Дорнод аймагт шинээр баригдсан ДЦС-г яаралтай ашиглалтад оруулж дутагдалтай байгаа эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэн шийдвэрлэх;

3. Орон нутгийн шийдвэр, нутгийн иргэдийн эсэргүүцэл болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанаас шалтгаалж түүхий тосны тээвэрлэлт саатах, зогсох асуудал гарсаар байна. Тухайлбал, Дорнод аймгийн Засаг даргын шийдвэрээр “Тосон-Уул XIX”, “Тамсаг XXI” талбайнуудын түүхий тосны тээвэрлэлтийн үйл ажиллагааг 1 сар зогсоож байсан бол “Машинтай жагсаал” ТББ болон “Нутгаа аврах Чойбалсанчууд” НҮТББ тавьсан шаардлага, эсэргүүцлээс

үүдэн экспорт тасалдах, газрын тосны экспортын орлогоос Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх орлого тасалдах болсон;

5.6 Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль, эрх зүйн орчин

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын бодлого, үйл ажиллагааг зохицуулсан 50 орчим хууль өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа бол Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад эрх олгосон зохицуулалтын хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 65 акт батлагдаж, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.

Салбарын эрх зүйн зохицуулалт нь 1992 оны Үндсэн хуульд тулгуурлаж байгаа бөгөөд 1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай хууль болон Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтууд нь газрын хэвлийн баялгийн өмчлөл, ашиглалтын талаар баримтлах үндсэн зарчим болж байна.

Түүнчлэн УИХ-ын 2009 оны 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолоор “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байна.

Цаашид салбарын хууль, эрх зүйн харилцаанд цаг үеийн шаардлагаар үүссэн харилцааг хуулиар зохицуулах, нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хүчингүй болсонд тооцох зэрэг шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

1. Аж үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх зорилгоор 2015 онд баталсан “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хууль 2020 онд хүчингүй болсон, өнөөгийн дагаж мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хууль нь ашигт малтмалын хайгуулаас баяжуулалт хүртэлх харилцааг зохицуулсан, Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан дэмжлэг нь зөвхөн паркт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулж байгаа бөгөөд паркийн гадна үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа хуулийн зохицуулалтгүй орхигдсон. Иймд хүнд үйлдвэрийн салбарт өндөр бүтээмжтэй, байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх, инженер, техник ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг шинэчлэх, хүнд үйлдвэрийн салбарын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Хүнд үйлдвэрийн тухай” (анхдагч) хуулийн төслийг боловсруулж батлуулах болон Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2. Газрын тостой холбогдсон зарим хуулиудын хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, газрын тосны эрлийн гэрээний загварыг батлах, эрэл хийх гэрээ байгуулах зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын тосны төрийн өмчит компани байгуулахтай холбогдуулан эрх, үүргийг тодорхойлох, шатдаг хий, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, чанарын хяналт тавих, зохицуулалтын механизмыг бий болгох, газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тооцооны тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүгнэлт өгөх зохицуулалтыг

нарийвчлах, газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох болон хуулийн зарим нэр томъёо, тодорхойлолтыг шинээр нэмж тусгах зорилгоор “Газрын тосны тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах;

3. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтуудын биелэлтийг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх замаар Үндэсний баялгийн санг арвижуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд “Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх” гэж заасны дагуу “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж батлуулах.

Хуулийн төсөл нь геологи, уул уурхайн салбарын тогтолцоо, хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох, ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа, түүний зарчим, тусгай зөвшөөрлийн зохицуулалт, уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, бичил уурхайн үйл ажиллагаа болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, геологи, уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт, нутгийн захиргааны байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан байна;

4. Газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартын хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн худалдаалах явдлыг хязгаарлах, хуурамч шатахуун үйлдвэрлэхэд ашиглагдах боломжтой түүхий эдэд онцгой албан татвар ногдуулах, импорт, үйлдвэрлэл, бөөн болон жижиглэнгийн худалдааны тусгай зөвшөөрлийн асуудлаар санал, дүгнэлт гаргах Мэргэжлийн зөвлөл байгуулах, эрх хэмжээний зохицуулалтыг тодорхой болгох болон хийн салбарын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж батлуулах;

5. Салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага хоорондын удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлох, чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох зэрэг болно.

5.7 Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчин

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлүүлэх, Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлүүлэх, Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн

хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгаж, энэ хугацаанд өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх, Хөрөнгө оруулалтын тогтворжуулалтын гэрчилгээ, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулахад Засгийн газраас баталгаа гаргуулах, ажилчдыг сургаж, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангах, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх зэрэг татварын болон татварын бус дэмжлэгийг авах боломжтой болсон.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалттай холбоотой харилцаа нь 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулагдаж байна. Уг хуулиар аливаа хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр заасан байдаг бөгөөд хуульд заасан шалгуурыг хангасан хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон байршлаас хамаарч хөрөнгө оруулалтын тогтворжуулах гэрчилгээг олгож байна.

Үүнээс Аж үйлдвэр, уул уурхай болон дэд бүтцийн салбарт 5-18 жилийн хугацаатай тогтворжуулах гэрчилгээ олгож байгаа бөгөөд ийнхүү олгохдоо аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тогтворжуулж байна. Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 16 компанид тогтворжуулах гэрчилгээ олгогдоод байгаагийн 4 нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын компани байна.

Мөн түүнчлэн тус хуулийн 20.1-д заасны дагуу 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагч нь Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой бөгөөд Монгол Улсын өнөөдрийн байдлаар хэмжээнд хөрөнгө оруулалтын 6 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнээс 3 нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбартай холбогдож байна.

Монгол Улс нь “Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц” (1965)-д нэгдэн орсон бөгөөд 43 улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, 26 улстай Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийг тус тус байгуулсан байдаг Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагчдад таатай хууль эрхзүйн орчин болно.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын дийлэнх нь ГШХО хэлбэрээр уул уурхайн салбарт хийгдэж байна.

2010-2020 оны хооронд уул уурхайн салбарт нийт 17.7 тэрбум ам.долларын ГШХО орсон бол үүнээс 2011 онд хамгийн өндөр буюу 4.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орсон нь тухайн үед хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 78 хувьтай тэнцэж байсан. Дээрх хугацаанд хийгдсэн ГШХО-ын 38 хувь буюу 9.17 тэрбум ам.доллар нь Канадаас, 21.3 хувь буюу 5.16 тэрбум ам.доллар нь БНХАУ-аас, 6.5 хувь буюу 1.56 тэрбум ам.доллар нь Сингапураас, 6.2 хувь буюу 1.49 тэрбум ам.доллар нь Люксембургийн Вант Улсаас тус тус хийгдсэн байна. 2020 оны

урьдчилсан гүйцэтгэлээр 1.68 тэрбум ам.долларт хүрсэн нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 41.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтай холбоотой тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

Салбарын хөрөнгө оруулалт нь ашигт малтмалын зах зээлийн үнэ болон эрэлтээс өндөр хамааралтай байдаг бөгөөд зах зээлийн гэнэтийн өөрчлөлт нь дотоодын макро эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлж байдаг. Тухайлбал, 2010-2011 онуудад уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарыг чиглэсэн хөрөнгө оруулалтын урсгал нь төлбөрийн тэнцэлд нөлөөлж, 2012 онд урсгал тэнцлийн алдагдал нь ДНБ-ний 27 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч байсан.

Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо, хэмжээ хэдийгээр өсч байгаа ч нэр, төрөл цөөн, технологийн агууламж бага, голдуу хагас боловсруулсан бүтээгдэхүүн хэлбэрээр экспортод гарч байгаа бөгөөд санхүүжилт болон борлуулалтыг дэмжих дэд бүтэц хангалтгүй, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд эргэлтийн хөрөнгө дутагдалтай, шинэ техник, технологи нэвтрүүлэх боломж хомс, импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байна.

5.8 Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүний нөөц

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар нь бүтээмж өндөр, хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний эрэлт ихтэй салбар юм.

Уул уурхайн хөгжлийг даган ашигт малтмалын олборлолт явагдаж буй бүс нутаг руу чиглэсэн хүн амын урсгал нэмэгдэж байгаа нь салбар хоорондын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг бий болгож байна. Үүний үр дүнд ур чадвартай ажлын байр уул уурхайн салбарт түлхүү нэмэгдэх болсон.

Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын дундаж цалин 2024 оны жилийн эцсийн байдлаар уул уурхайн салбарт мөн адил хамгийн өндөр буюу 3.29 сая.төгрөг байгаа нь улсын дунджаас 2.4 дахин их үзүүлэлт юм.

Уул уурхайн салбар 2024 оны 2 дугаар улиралд хамгийн их буюу 56,327 ажлын байр бий болгосноос 81 хувь нь эрэгтэй ажиллагсад, 19 хувийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлж, хүйсийн харьцаа 4:1 байна. Салбарын хэмжээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/114 дүгээр тушаалаар “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг (2019-2026) батлагдан хэрэгжиж байна.

Ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, боловсруулалттай холбогдсон үйл ажиллагаа нь нарийн мэргэжил, мэргэшил шаарддаг учир дотоодоос ажиллах хүчээр бүрэн хангахад хүндрэлтэй байдаг. Иймд, ялангуяа уурхайн бүтээн байгуулалтын үед гадаадаас цөөнгүй ажиллах хүчийг квотоор ажиллуулдаг.

Цаашид салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд дараах асуудал тулгарч байна. Үүнд:

1. Салбарын ажиллах хүчний мэдлэг, чадвар өнөөгийн техник технологийн шаардлагад тэр бүр нийцэхгүй байна. Дэвшилтэд техник технологи, нарийн мэргэжлийн ажиллах хүчин нь эрдэс баялгийн салбарын урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах үндсэн нөхцөлийн нэг тул салбарын ажиллах хүчийг ирээдүйд бий болох технологийн дэвшил, мэргэжил, ур чадварт тулгуурлан бэлтгэх;

2. Эрдэс баялгийн салбарын тогтвортой үйл ажиллагаа нь ашигт малтмалын зах зээлийн үнэ ханшны өөрчлөлт, хөрөнгө оруулалт, төрөөс баримтлах бодлого, шийдвэрээс өндөр хамааралтай байдаг тул салбарын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн байдал тогтворгүй байна;

3. Салбарын хэмжээнд залуу, мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчин бэлтгэгдэн гарч байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээлийн болон капиталын оновчгүй хуваарилалтаас үүдэн бүтээмжийн өсөлт сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна;

4. Салбарын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан хөдөлмөрийн нөхцөл хүнд, ажлын байрны осол, гэмтэл их гардаг тул геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журмыг боловсронгуй болгох зэрэг тус тус болно.

Байгууллагын SWOT шинжилгээ

	Давуу тал	Сул тал
Дотоод	<ul style="list-style-type: none"> - Төсвөөс санхүүждэг; - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудал нь өргөн хүрээг хамардаг; - Ажиллах орчин, нөхцөл бүрдсэн; - Байгууллагын дотоод үйл ажиллагааны журам, заавар, албан хэрэг хөтлөлт сайн, сүлжээний програм хангамжийг нэвтрүүлсэн; - Мэргэшсэн боловсон хүчин сайтай; - Үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжид илүү анхаардаг. 	<ul style="list-style-type: none"> - Стратеги, төлөвлөлт хангалтгүй; - Салбарын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй; - Байгууллагын дотоод нэгжүүдийн уялдаа холбоо, мэдээлэл солилцох байдал хангалтгүй; - Орон нутагт харьяа нэгж, салбар байхгүй; - Алба хаагчдын ажил үүргийн хуваарь жигд бус; - Алба хаагчдын албан тушаал дэвших, албан тушаалын ангилал зэрэглэл, зэрэг дэв ахиулах асуудал нээлттэй биш; - Төрийн алба хаагчийн мэргэшсэн, тогтвортой байх зарчмын хэрэгжилт сул.
	Боломж	Эрсдэл
Гадаад	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын бодлого, үйл ажиллагааны нийгмийн хүлээлт өндөр; - Эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл их; - Зах зээлийн таатай үе ирж байгаа; - Гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх; - Боловсон хүчнийг бэлтгэх, дахин сургах. 	<ul style="list-style-type: none"> - Улс төрийн тогтворгүй байдал нь байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх; - Гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр төсөл хөтөлбөрийн хэрэгжилт удаашрах, зогсох; - Албан хаагчид авилга, албан тушаалын хэрэгт холбогдох; - Салбарт гарсан аливаа алдаанаас үүдэн байгууллагын нэр хүнд унах.

Байгууллагын SWOT шинжилгээний үр дүнд тулгуурлан АҮЭБЯ нь дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

1. Салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги:

Байгууллагын менежментийг сайжруулах, иргэдэд мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэх, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, албан хаагчдын мэдлэг, чадвараа дээшлүүлэх боломжийг дэмжих, томоохон төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт татах.

2. Салбарын гадаад орчны таатай боломжийг ашиглан сул талыг сайжруулах стратеги:

Байгууллагын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, байгууллагын бодлого, үйл ажиллагааны стратеги, төлөвлөлтийг боловсронгуй болгох, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, төсөл, хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах, орон нутагт яамны харьяа нэгж байгуулах, цахим засаглалыг байгууллагын хэмжээнд хөгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийг системтэй бэлтгэх.

3. Салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны эрсдэлийг даван туулах стратеги:

Салбарын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох, байгууллагын албан хаагчдийг авилга, албан тушаалын хэргээс ангид байлгах.

4. Салбарын гадаад орчны эрсдэлтэй нөхцөлд сул талаа сайжруулах замаар сөрөг үр дагаврыг бууруулах стратеги:

Томоохон төслийг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааны оновчтой механизмыг бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн албан хаагчдын тогтвортой ажиллах боломжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар байгууллагын нэр хүндийг өсгөх.

6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Орчны шинжилгээний үр дүнд суурилан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь 2026-2029 онд дараах стратегийн зорилгуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Геологи-хайгуулын ажлыг нэмэгдүүлж, ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөн олборлох салбарыг эрдсийн түүхий эдээр тогтвортой хангах;

2. Уул уурхайн салбарын ДНБ-нд эзлэх хэмжээг 30 хүртэл хувьд хүргэж, эдийн засгийн өсөлтийг хангах;

3. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарлыг 50 хүртэл хувиар бууруулж, бүтээгдэхүүн хангамжийн тогтвортой байдлыг хангах;

4. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бодит өсөлтийг 2029 онд 5.9 хувьд хүргэж, ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх;

5. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулж, баялгийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх;

6. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, уул уурхай, олборлолтын гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хэмжээг 70-аас дээш хувьд хадгалах;

7. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх;

8. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааг цахимжуулах ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

9. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааны стратегийг боловсруулах, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж чанар, аюулгүй байдлыг хангуулах тус тус болно.

7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ




Төлөвлөгөөг баталсан:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
(албан тушаал)

Тэмдэг

/Г.Дамдинням/



(огноо)

Төлөвлөгөө боловсруулсан:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

Тэмдэг

/Б.Дашпүрэв/

(огноо)



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2026-2029 ОН)

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр /сая төгрөг/
<p>1. Ерөнхий чиг үүргийн нэр: Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого төлөвлөлт, хөгжлийн стратеги, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.</p> <p>Үндсэн чиг үүрэг: Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого, стратегийг бодлогын үр нөлөө, уялдаа, хувилбарыг нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн тодорхойлж эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрдэс түүхий эдийг боловсруулах, металлургийн, химийн, метал хийцийн болон машин үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлдвэрлэл, технологийн паркийг бүсчилсэн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгох, шаардлагатай статистик мэдээ, мэдээлэл бэлтгэх, салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, судалгааг хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх, хөтөлбөр, төсөлд үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.</p>	<p>1.1. Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого, чиглэл, стратегийг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн санал, төсөл, төлөвлөгөө, боловсруулах, батлуулах, биелэлтийг тайлагнах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Боловсруулсан, батлуулсан баримт бичгийн тоо</p>	<p>0</p>	<p>4</p>	<p>Улсын төсөв</p>
<p>Зорилт-1: Аж үйлдвэрийн салбарын стратегийн зорилтыг тодорхойлж, салбарын бодлогыг бусад салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд зорилго, зорилттой уялдуулж,</p>					

<p>урт, дунд, богино хугацаанд төлөвлөх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг болон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах</p>	<p>1.2. Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого, чиглэл, стратегийг тодорхойлох, хөгжлийн бодлого тодорхойлоход шаардагдах салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, судалгааг хийж тэдгээрт тулгуурласан бодлогын шийдлийг боловсруулж санал болгох</p>	<p>Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв</p>
	<p>1.3. Хүнд үйлдвэрийн тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах</p>	<p>Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв</p>
	<p>1.4. Салбарын эдийн засаг, татвар, хөрөнгө оруулалтын орчин, техник, технологи, түүхий эдийн хангалт, нийлүүлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, зах зээл, экспорт, импорт, үнэ, эрэлт хэрэгцээний судалгаа хийх, статистик тоо баримт, мэдээллийг бүрдүүлэн, нэгтгэн боловсруулж мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, удирдлага, албан хаагч, холбогдох байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах.</p>	<p>Мэдээлэл бүрдүүлэлтийн хувь</p>	<p>10</p>	<p>30-40</p>	<p>Улсын төсөв</p>
<p>Зорилт -2: Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хэрэгцээ,</p>	<p>2.1. Аж үйлдвэр (хүнд үйлдвэр), үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль</p>	<p>Санал боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв</p>

<p>шаардлагыг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн бодлогтой уялдуулан хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоог дэмжих, паркийн хөгжлийн төлөвлөлтийг дэд бүтцийн хамтаар боловсруулах, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлагнах</p>	<p>болон холбогдох дүрэм, журам, заавар, норматив, стандарт, аргачлал, маягт, боловсруулах, нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах</p>		
<p>2.2. Шинээр үйлдвэрлэл, технологийн парк байгуулах сонирхол бүхий аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээн авах, судлах, шийдвэрлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, журмын дагуу шаардлага хангасан төслүүдийг эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх</p>	<p>Хүсэлт шийдвэрлэсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)</p>	0	Ирүүлсэн хүсэлтийн тоогоор Улсын төсөв
<p>Зорилт -3: Аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах, хүнд үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх хувилбар боловсруулах, статистик мэдээ, мэдээлэл, судалгааны нэгдсэн санг бүрдүүлэх, хөтөлөх, олон нийтийг нээлттэй ил тод</p>	<p>3.1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн байгуулах Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.</p> <p>3.2. Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн стратегийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг</p>	1	Дэмжлэг үзүүлсэн эсэх: (Тийм:1, Үгүй:0)
	<p>Удирдамжаар хангасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)</p>	1	1

мэдээллээр хангах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоог дэмжих	эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.				
3.3. Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	0	1	1	-
3.4. Багануурын уурхайг түшиглэн байгуулах "Пироллиз, эрчим хүчний үйлдвэр"-ийн төслийн ажлыг хангахад холбогдох байгууллагатай хамтран ажиллах.	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	-
3.5. Тавантолгой үйлдвэр технологийн паркийг түшиглэн Кокс химийн цогцолбор төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад бодлого, зорхион байгуулалтын дэмжлэг үзүүлэх.	Дэмжлэг үзүүлсэн эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	-
3.6. "Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр"-ийн төслийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах.	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	-

	<p>3.7. Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах.</p> <p>3.8. Гэрэлт говь үйлдвэрлэл, технологийн парк байгуулах коксын үйлдвэрийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах.</p>	<p>Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)</p>	1	1	-
<p>Зорилт -4: Аж үйлдвэрийн салбарт шинжлэх ухааны ололт амжилтад суурилсан дэвшилтэт, тэргүүний логи, инновацыг нэвтрүүлэх, ногоон хөгжлийн төслүүдийг дэмжлэг үзүүлэх</p>	<p>4.1. Аж үйлдвэрийн салбарт тэргүүний технологи, инновацыг нэвтрүүлэх судалгааг хийх, ногоон хөгжлийн төслүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p> <p>4.2. Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх, үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий</p>	<p>Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)</p>	1	1	-

	зөвлөлийн хурлыг зохион байгуулах.					
	4.3. Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Засгийн газар хоорондын комиссын Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны асуудлаарх дэд комиссын үйл ажиллагааг зохион байгуулах, оролцох.	1	1	1	Уйл ажиллагааг зохион байгуулсан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	-
Зорилт -5: Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшсэн мэргэжилтнийг бэлтгэх чиглэлээр холбогдох сургалтын болон төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан, хөтөлбөр боловсруулж хамтран ажиллах	5.1. Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийн нэгдсэн цогц бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх 5.2. Салбарын хүний нөөцийн судалгаа хийх, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, шаардлагатай ажиллах хүч, мэргэжилтнийг гадаадаас авах, гадаад дотоодод сургах, дадлагажуулахад мэргэжлийн сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.	0	1	0	Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	Улсын төсөв
		1	1	1	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	-
Зорилт -6: Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай	6.1. Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, стандарт, нормативыг боловсруулах.	1	1	1	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	-

холбоотой дүрэм, журам, стандарт, норм нормативыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах	хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.				
Зорилт -7: Аж үйлдвэрийн салбарын болон салбар хоорондын уялдааг хангах хэмжээний акт, дүрэм, норм, техникийн шаардлага, стандарт, итгэмжлэл, нийцлийн холбогдолтой бичиг баримтыг боловсруулах, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	7.1. Аж үйлдвэрийн салбарын болон салбар хоорондын уялдааг хангах дүрэм, журам, стандарт, норм, нормативыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана. 7.2. Аж үйлдвэрийн салбарын дүрэм, журам, стандарт, нормативын хэрэгжилтийн байдалд үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах, эрх бүхий байгууллагатай хамтран хяналт хэрэгжүүлж ажиллана.	1	1	1	-

2. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын хэрэгжилтийг хангах, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.

Үндсэн чиг үүрэг-1: Геологи, эрдэс баялгийн салбарын бодлого, хууль тогтоомж, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, олон нийтэд таниулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон шийдвэр гаргахад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.						
Зорилт-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах	1.1. Эрдэс салбарын байдал, хүрсэн үр дүнд дүн шинжилгээг хийж, цашид авах арга хэмжээний санал боловсруулах.	Баялгийн өнөөдрийн	Боловсруулсан саналын тоо	0	1	Улсын төсөв
